



СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН КАМПАНИТ АЖЛЫН ХУВААРЬ

Бакалавр, магистр, аспирантур, ординатур*, орос хэлний Зуны сургуульд* суралцах хүсэлтэй горилогчид дараах үе шатыг амжилттай давах ёстой. Үүнд:

I	21.09.01-2021.10.31	education-in-russia.com сайт дээр заавал бүртгүүлэх. Хавсралт 1-д заасан жагсаалтын дагуу хувийн баримт бичгийн скан-хуулбарыг байршуулах. (https://drive.google.com/file/d/1E3pGyiAclLkLvTXm4nIVNfpWov6Ka2Vwx/view?usp=sharing)
	21.11.01-2021.11.14	Бүртгэлийн комисс ирүүлсэн мэдүүлгийг шалгах;
	Анхаар!	<p>Портфолио шалгаруулалтанд (гол бус хичээлд хоёроос дээшгүй «С» буюу «дунд» үнэлгээтэй) боловсролын гэрчилгээ бүхий горилогчдыг оруулна;</p> <p>1-2-р ангийн оюутнууд аттестат (түүнд гол бус хичээлд хоёроос дээшгүй «С» буюу «дунд» үнэлгээтэй байж болно) ба тухайн их дээд сургуулийн сургалтын хэлтсийн тамга бүхий сурлагын тодорхойлт (дундаж оноо нь 2.8, оросын боловсролын стандартаар бол 4-өөс доошгүй байна)-ыг тус тус хавсрагна.</p> <p>Магистр, аспирантурд суралцах горилогчдын дипломны дундаж оноо нь монголын боловсролын стандартаар 2.8, оросын боловсролын стандартаар 4-өөс доошгүй байна. Тухайн мэргэжлийн голлох хичээлийн жагсаалтыг эндээс үз. Хавсралт 1.1. (https://drive.google.com/file/d/1V6EmAmtYur1arIUBdq8glGrNq-PyY1Gy/view?usp=sharing)</p>
II	21.11.15-2021.11.20	Горилогчдын баримт бичгийг бэлтгэн Экспертын комисст явуулах
	21.11.20-2021.12.24	Экспертын комиссийн гишүүд “Портфолио шалгаруулалт”-ын элсэлтийн шалгалтыг явуулах Хавсралт 2. (https://drive.google.com/file/d/1HvBneYjoXbOJJ9r90KmBaotDJPx70cdS/view?usp=sharing)



	2021.11.23	Аспирантур, ординатур* чиглэлээр суралцах горилогчдын дунд хийх онлайн хэлэлцүүлэг-шалгалт (ZOOM-д орох ишлэл ба шалгалт явуулах цагийг горилогчийн хувийн кабинет дахь цахим хаягаар явуулна / education-in-russia.com/).
	2021.11.24	Магистр, Зуны сургалтанд хамрагдах горилогчдын дунд хийх онлайн хэлэлцүүлэг-шалгалт (ZOOM-д орох ишлэл ба шалгалт явуулах цагийг горилогчийн хувийн кабинет дахь цахим хаягаар явуулна / education-in-russia.com/).
	2021.11.26	Урлагийн мэргэжлээр суралцах горилогчдын дунд хийх онлайн хэлэлцүүлэг-шалгалт (ZOOM-д орох ишлэл ба шалгалт явуулах цагийг горилогчийн хувийн кабинет дахь цахим хаягаар явуулна / education-in-russia.com/). <i>Урлагийн чиглэлийн элсэлтийн нэмэлт шалгалтыг явуулах хугацаа, газрын талаарх мэдээллийг боловсролын байгууллагуудын сайт дээр байршуулна. Горилогч шалгалтанд оролцох хугацаа болон тавигдах шаардлагын талаарх мэдээллийг өөрөө тодруулах шаардлагатай. ОХУ-ын Соёлын яамны харъяа дээд боловсролын сургуулиудын тухай мэдээллийг дараах ишлэлийг ашиглан олж танилцах боломжтой:</i> https://culture.gov.ru/about/subordinates/obrazovatelnye_organizatsii_vysshego_obrazovaniya/ , түүнд боловсролын байгууллагуудын интернет-сайтын хаяг тусгагдсан байна.
	2021.12.29	“Портфолио шалгаруулалт”-ыг амжилттай давсан горилогчдын эцсийн нэрсийг Русский Дом в Улан-Баторе-ийн https://www.facebook.com/RCNKUB гэсэн сошиал сүлжээнд байршуулна.
III	21.12.29-2022.01.14	Сонгон шалгаруулалтын хоёрдугаар шатанд оролцох горилогчдын бүрэн баримт бичгийн бүрдүүлэлтийг education-in-russia.com системд хийх. /Хавсралт 3/ (https://drive.google.com/file/d/1AaHN6MAbqe4tjrkrfq4vWNcSZxF9TKjAl/view?usp=sharing)
	22.01.15-2022.01.31	Горилогчдын баримт бичгийн бүрдүүлэлтийн чанар хийгээд баримт бичиг бүрэн орсон эсэхийг бүртгэлийн комисс шалгах.



IV	2022.02.01	Гадаадын иргэдийн дунд явуулсан сонгон шалгаруулалтын нэгдүгээр шатны дүнг Россотрудничество агентлагийн төв аппарат руу явуулах.
V	22.02.01-2022.03.01	2022/23 оны хичээлийн жилд ОХУ-ын Засгийн Газрын тэтгэлэгээр Оросын Холбооны Улсад суралцах гадаадын иргэн, иргэншилгүй хүмүүс болон гадаадад амьдарч буй эх орон нэгтнүүдийн дунд явуулсан сонгон шалгаруулалтын нэгдүгээр шатны дүнг Тусгаар Улсуудын Хамтын Нөхөрлөл, гадаадад суугаа эх орон нэгтнүүдийн асуудал эрхэлсэн болон олон улсын хүмүүнлэгийн хамтын ажиллагааны Холбооны агентлаг /Россотрудничество /-д хэлэлцэх.
VI	22.03.01-2022.06.01	2022/23 оны хичээлийн жилд ОХУ-ын Засгийн Газрын тэтгэлэгээр Оросын Холбооны Улсад суралцах гадаадын иргэн, иргэншилгүй хүмүүс болон гадаадад амьдарч буй эх орон нэгтнүүдийн дунд явуулсан сонгон шалгаруулалтын нэгдүгээр шатны дүнг ОХУ-ын Шинжлэх ухаан, дээд боловсролын яаманд хэлэлцэх.
VII	22.06.01-2022.07.01	Боловсролын байгууллагууд горилогчдын баримт бичгийг хэлэлцэх замаар горилогчдын анкетын дагуу сонголтоо хийх.
VIII	22.03.01-2022.08.05	Урлагийн чадвар, бие бялдар эсвэл сэтгэл зүйн зохих чадвар шаардсан тусгай мэргэжил /бэлтгэлийн чиглэл, мэргэжил/-ээр суралцах горилогчдоос урлаг хийгээд мэргэжлийн онцлог чиглэлээр нэмэлт элсэлтийн шалгалтыг боловсролын байгууллагуудад өгөх. Урлаг хийгээд мэргэжлийн онцлог чиглэлээр нэмэлт элсэлтийн шалгалт авах хуваарийг навигатор /чиглүүлэгч/-ын үндсэн хуудас https://russia-edu.minobrнауки.gov.ru/ дээр тусгасан байна.

* Ординатур ба Орос хэлний Зуны сургуульд суралцах горилогчдод заавал тавихдах шаардлага орос хэлийг чөлөөтэй эзэмшсэн байх.



* ОХУ-ын иргэнийг суралцуулах тухайд дараах зүйлийг мэдэгдье: эдгээр горилогчид нь ОХУ-ын нутаг дэвсгэр дээр байнгын бүртгэлгүй байх ёстой. Бүртгэлээс хасуулсан баримт бичигтэй бол уг бичгийн огноо нь 2021 оны 9-р сарын 1-ээс хойш байж болохгүй.

* “Ноорог” байдлаар бичигдсэн мэдүүлгийг хүлээн авахгүй !!!